



Улаанбаатар телевиз



NTV телевиз



MONGOLIAN NATIONAL BROADCASTER



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ




Посольство
Российской Федерации
в Монголии



Российский центр
науки и культуры в
Улан-Баторе



ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ОХУ-ын ЭСЯ, БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр Оросын шинжлэх ухаан соёлын төвд (РЦНК)



РОССИЙСКАЯ
ОБРАЗОВАТЕЛЬНАЯ
ВЫСТАВКА



ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2017 03.16-18

РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА 2017



2017.03.16-18



Эрхэм хүндэт Монголын оюутан, сурагч, залуучууд аа!

2 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа "Оросын боловсролын үзэсгэлэн EXPO-2017" арга хэмжээгээрээ та бүхэнтэйгээ дахин уулзахдаа бид баяртай байна. Та бүхний хүсэлт, эрэлт хэрэгцээнээс үүдэн манай энэ удаагийн үзэсгэлэн хүрээгээ улам тэлж "Гадаад дахь оросын боловсрол" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулан, ОХУ-ын өнцөг булан бүрээс дэлхийн ТОП-100-д ОХУ-ын ТОП 10-т ордог 20 гаруй шилдэг их дээд сургуулиуд та бүхэнд оюуны хөрөнгө оруулалт хийхээр хүрэлцэн ирээд байна.

Түүнээс гадна Орос орон энэ жил урьд жилүүдэд байгаагүй тоогоор буюу 450 тэтгэлэгт хуваарийг та бүхэнд санал болгож, бид та бүхэнд энэ үеэр хэрхэн тэтгэлэгт хамрагдах, шалгалтаа амжилттай өгөх, суралцахаар явах зэрэг сонирхолтой сэдвүүдээр ярилцлага хийх болно.

Орос орон бол дэлхийн хүчирхэг гүрэн. Оросын боловсрол, соёл, урлаг, яруу найраг, уран зохиол, шинжлэх ухаан, техник технологийн нээлт, ололтоороо үргэлж тэргүүлэх байр суурь эзэлдэг. Тэгвэл та бүхэн энэхүү эрдэм мэдлэг, авьяас чадвар, дадлага туршлагаас хуваалцахыг хүсвэл Москва, Санкт-Петербург, Томск, Красноярск, Иркутск, Якутск, Тува, Адыгей, Екатеринбург, Белгород, Ростов-на-Дону, Владивостокоос хүрэлцэн ирсэн сургуулиуддаа суралцахыг урьж байна!

Бид Орос орны нүүр царай болсон эдгээр сургуулиудыг санал болгохдоо сэтгэл дүүрэн байна. Та бүхний сонголт мэргэн, ирээдүй тань гэгээлэг байх болтугай!

Е.Г.Михайлов

ОХУ-ын Монгол Улс дахь ЭСЯ-ны Зөвлөх,
Россотрудничество агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал

"ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН-2017" ХӨТӨЛБӨР

ПҮРЭВ. 2017 ОНЫ 3 САРЫН 16 ӨДӨР 09⁰⁰-19⁰⁰

- 09⁰⁰-10⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл
- 11⁰⁰-19⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа
- 11⁰⁰-11³⁰ Хэвлэлийн бага хурал
- 15⁰⁰-16⁰⁰ Үзэсгэлэнгийн албан ёсны нээлтийн ажиллагаа
- 16⁰⁰-16³⁰ "Гадаад дахь Оросын боловсрол" сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлын нээлт
- 11⁰⁰-19⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын танилцуулга, презентаци (видеогоор)
- 13⁰⁰-14⁰⁰ Тэтгэлэгт бүртгүүлэгчдэд өгөх зөвөлгөө (том заал)
- 16⁰⁰-19⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (оролцогчдын хүсэлтээр)
- 11⁰⁰-19⁰⁰ Элсэлтийн тест, сорилын шалгалт (РЦНК-ийн номын сан)

БААСАН. 2017 ОНЫ 3 САРЫН 17 ӨДӨР 09⁰⁰-19⁰⁰

- 09⁰⁰-19⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа
- 10⁰⁰-19⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын танилцуулга, презентаци (цагийн хуваарийн дагуу, бага заал)
- 10⁰⁰-16³⁰ Эрдэм шинжилгээний хурлын үргэлжлэл (Г.В.Плехановын нэрэмжит ОЭЗИС-ийн салбарт)
- 10⁰⁰-19⁰⁰ "Оросод суралцаж амьдрах боломж" үзэсгэлэн үзэгчдийн Оросод төгсөгчидтэй хийх уулзалт
- 16⁰⁰-19⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (оролцогчдын хүсэлтээр)
- 16³⁰-17³⁰ Хонжворт сугалааны азтан тодруулах
- 11⁰⁰-19⁰⁰ Элсэлтийн тест, сорилын шалгалт (РЦНК-ийн номын санд)

БЯМБА. 2017 ОНЫ 3 САРЫН 18 ӨДӨР 09⁰⁰-14⁰⁰

- 09⁰⁰-14⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа
- 09⁰⁰-12⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын танилцуулга, презентаци (видеогоор)
- 09⁰⁰-13⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (оролцогчдын хүсэлтээр)
- 10⁰⁰-12⁰⁰ Элсэлтийн тест, сорилын шалгалт (РЦНК-ийн номын санд)
- 12³⁰-13³⁰ Үзэсгэлэнд оролцогчдын ОХУ-ын ЭСЯ-ны зөвлөх, Россотрудничество агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал Е.Г.Михайлов болон Монгол Улс дахь ОХУ-ын ЭСЯ-ны төлөөлөгчидтэй хийх уулзалт
- 14⁰⁰ Үзэсгэлэнгийн хаалт
- 14³⁰-16³⁰ Үзэсгэлэнгийн хүндэт зочид болон оролцогчдод зориулсан Хаалтын хүлээн авалт. Сертификат гардуулах



КРАСНОЯРСКИЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Красноярский хөдөө аж ахуйн улсын их сургууль бол хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, эдийн засаг, менежмент болон хуулийн чиглэлээр дээд, дунд боловсролын хөтөлбөрүүдийн дагуу өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг орчин үеийн боловсролын төв юм.

Өнөөдрийн байдлаар Красноярский хөдөө аж ахуйн улсын их сургууль нь Сибирийн нутаг дэвсгэр дээрх томоохон сургуулиудын нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд мэргэжилтнүүдийг чанарын өндөр түвшинд бэлтгэх бүхий л шаардлагатай материал техникийн баазар хангагдсан. 14000 гаруй оюутнууд бакалаврын 23, магистрын 8, дунд боловсролын 5 мэргэжлийн чиглэлээр суралцаж байна.

Оюутнууд нь ОХУ-ын бүхий л мужуудын орос иргэд байхаас гадна мөн гадаадын иргэд ч байдаг. Сургуулийн хэрэгжүүлж буй заах арга барил нь гадаад улсуудын иргэд их сургуулийн орчинд амархан дасах, орос хэлийг сайн сурах бүхий л боломжийг олгодог.

Боловсролын үйл ажиллагаа явуулах эрх нь их сургуулийн лиценз, улсын аттестатчилалд хамрагдсанаар баталгааждаг. Эзэмшсэн боловсролын чанар нь ОХУ-ын болон олон улсын менежментийн чанарын

сертификатуудаар батлагдах бөгөөд, энэ нь манай оюутнууд Европын түвшинд боловсрол эзэмшдэгийг гэрчилж байгаа юм.

2014 оноос менежментийн салбарын бакалавр, магистрын бэлтгэл нь олон улсын аттестатчилалын дагуу явагдаж байгаа. Төгсөгчид нь улсын хэмжээний диплом авах ба энэ нь хөдөө аж ахуй газар тариалангийн

салбарын төрийн болон бизнесийн байгууллагуудын ажил олгогчдод бүрэн хүлээн зөвшөөрөгддөг. Мөн дипломонд хавсралтаар Европын стандартын сертификат олгогддог.

Красноярский хөдөө аж ахуйн улсын их сургууль нь ЕБДС төгсөгчдийг Сибирийн төв болох Красноярск хотод дээд болон дунд мэргэжлийн боловсрол эзэмшихийг урьж байна.



Сургалтын төлбөр нь эзэмших мэргэжлээс шалтгаалах бөгөөд, өдрөөр суралцвал 679 – 1593, эчнээгээр суралцвал 329 – 679 ам.доллар байдаг. Бүх оюутнууд нь сургуульдаа ойрхон оюутны байрандаа байрлах боломжтой.



ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ХОЛБОГДОХ ХАЯГ:


ОХУ, Красноярск хот, Елена Стасовагийн гудамж, 44 байр
Утас: +7 391 227 30 09;
+7 391 247 21 35.

И-мэйл: priem@kgau.ru;

agropriem@kgau.ru

Вэбсайт: www.kgau.ru

(монгол хэл дээрх мэдээлэл
Монгол гэсэн хэсэгт байгаа)



В.Г. ШУХОВЫН НЭРЭМЖИТ БЕЛГОРОДИЙН ТЕХНОЛОГИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ.

В.Г.Шуховын нэрэмжит Белгородийн технологийн улсын их сургууль /В. Г. Шуховын нэрэмжит БТУИС/ бол барилгын материал ба барилга байгууламжын үйлдвэрлэлийн салбар дахь оросын мэргэшсэн томоохон дээд сургуулиудын нэг бөгөөд дэлхийн боловсрол, ШУ-ны орон зайд зохистой байр суурь эзэлдэг юм. БТУИС-ийн мэргэжилтэн бэлтгэх түвшин боловсрол, ШУ-ны нийгэмлэгт өндөр үнэлгээ авсаар ирсэн. Ижил төрлийн их сургуулиудын дунд БТУИС олон жил нэгдүгээр байр эзэлж байгаа ба оросын дээд сургуулиудын шилдэг 100-д багтдаг.

Их сургуулийн бүрэлдэхүүнд 9 дээд сургууль, 42 кафедрайт: Архитектур-барилгын дээд сургууль, Машин үйлдвэрлэл ба технологийн дээд сургууль, Эрчим хүч, мэдээллийн технологи ба удирдлагын системийн дээд сургууль, Тээвэр-технологийн дээд сургууль, Эдийн засаг ба менежментийн дээд сургууль, Хими-технологийн дээд сургууль мөн магистрын дээд сургууль, Эчнээ сургалтын дээд сургууль, зайн технологи ашиглан эчнээ сургалт явуулдаг дээд сургууль зэрэг байна.

БТУИС-ийн сургалт олон түвшинтэй ба олон чиглэлтэй байдаг. Их сургуульд бакалаврын

37 чиглэлээр, 11 мэргэжилээр, магистрын 27 чиглэлээр мөн аспирантурын 15 чиглэлээр сурч болно.

35 га газар дээр сургалт-лабораторийн байрнууд, туршилт-үйлдвэрлэлийн бааз, ШУ-техникийн номын сан, спорт иж бүрдэл, оюутны соёлын ордон, оюутны дотуур байрнууд мөн багш нарын байртай, хүнсний



үйлдвэрлэлтэй орчин үеийн их сургуулийн иж бүрдэлийг байгуулсан.

Өнөөдрийн байдлаар БТУИС-д 25 орчим оюутан, 1500 европ, ази, америкийн орнуудын иргэд боловсрол эзэмшиж байна. Гадаадын дээд сургуулиудтай хамтын ажиллагааны олон гэрээтэй. Гадаадын иргэдэд зориулсан бэлтгэл факультет ажилладаг. Хоёр дипломтой мэргэжлийн боловсролын хөтөлбөр хэрэгждэг.

Их сургуулийн сургалт эрхлэх эрх улсын магадлан итгэмжлэлийн

лицензээр баталгаажсан. Сургууль төгсөөд төгсөгчид ОХУ-ын боловсрол, ШУ-ны яамаар тогтоогдсон дипломыг гардан авна.

БТУИС боловсролтой болох, хувь хүний бүх талын хөгжил, мэдлэгийн хүрээгээ өргөжүүлэх, соёлын түвшингөө дээшлүүлэх маш өргөн боломжийг нээж өгнө. Сургалтын төлбөр сурч буй мэргэжлээс хамааран өдрийн ангийн хэлбэрээр 1359-2535, эчнээ хэлбэрээр 648-988 америк доллар байна. Бүх оюутнууд дотуур байраар хангагдана.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Россия, 308012, г. Белгород,
ул. Костюкова 46, БГТУ им. В.

Г. Шухова

Утас: (4722) 55-41-03, 30-99-07

И-мэйл: pr-com-bgtu@mail.ru

Гадаад оюутны бэлтгэл
факультет:

Утас: (4722) 30-99-19,

(4722)42-08-08

И-мэйл: rki-bgtu1@yandex.ru



ЭРХҮҮГИЙН ЗАМ ХАРИЛЦААНЫ ИХ СУРГУУЛЬ



Эрхүүгийн зам харилцааны их сургууль (ИрГУПС) 1975 онд Эрхүүгийн төмөр замын тээврийн дээд сургууль нэртэйгээр байгуулагдсан бөгөөд ОХУ-ын 5 субъектийг хамарсан бүс нутаг хоорондын тээврийн их сургуулийн томоохон цогцолбор юм. Сургууль нь ОХУ-д 5, Монгол улсад 1 салбар сургуультай. Өнөөдөр тус их сургуульд 22598 оюутан суралцаж, 580 эрдэмтэн багш ажилладгаас 66 нь шинжлэх ухааны доктор, 321 нь дэд эрдэмтэн юм. 31 мэргэжлээр бакалавр, магистр, 22 мэргэжлээр мэргэжлийн дунд боловсролыг олгож байна.

Манай сургуулийн олон улсын хамтын ажиллагааны түүх 1986 онд монголын 9 иргэнийг улсын тэтгэлгээр сургаж эхэлснээр эхэлсэн түүхтэй. 1992 онд манай сургууль монгол-оросын нээлттэй хувьцаат нийгэмлэг Улаанбаатар төмөр замтай мэргэжилтэн бэлтгэх гэрээ байгуулсан бөгөөд энэ хугацаанд 320 монгол иргэд төмөр замын мэргэжилтнээр суралцан төгссөн юм. Өнөөдөр Эрхүүгийн улсын зам харилцааны их сургуулийн 1-5-р курст монголын 169 оюутан, бэлтгэл ангид 30 сонсогч, Улаанбаатар дахь салбар сургуульд 45 сонсогч, 17 аспирант тус тус суралцаж байна.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Адрес: Сибирский федеральный округ, 664074, Иркутск, ул. Чернышевского, 15, оф.119 Д

Телефон: (3952) 638-340

И-мэйл: shunick@irgups.ru pk@irgups.ru



ТОМСКИЙ ПОЛИТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛЬ



ТОМСКИЙ ПОЛИТЕХНИЧЕСКИЙ УНИВЕРСИТЕТ




Томский политехникийн их сургууль/ТПИС/ 1896 онд байгуулагдсан бөгөөд үндэсний судалгаа шинжилгээний их сургуулийн статустай. ТПИС нь ОХУ-ын инженерийн боловсрол олгох нэг лидер бөгөөд ТОП-10 их сургуулийн нэгд ордог.



Тус сургуульд 16000 орчим оюутан суралцдаг бөгөөд тэдгээрийн 4147 нь дэлхийн 50 орноос ирсэн гадаад гадаад оюутнууд юм. ТПИС нь оросын их дээд сургуулиудын дэлхийн тэргүүний шинжлэх ухаан-боловсролын төвүүдтэй өрсөлдөх чадварыг дээшлүүлэх "5-100" төслийн 15 ялагчийн нэг бөгөөд олон улсын CESAER, CLASTER консорциум, БРИКС-ийн сүлжээний их сургууль, энэтхэг оросын тэргүүлэх их сургуулиудын холбооны гишүүнээр тус тус ажилладаг. Тус сургуулийн боловсролын 40 хөтөлбөр олон улсын ABET, EUR-ACE байгууллагуудын гэрчилгээ авсан. ТПИС QS World University Rankings байгууллагын 2016-2017 оны рейтингт 400-р байрыг эзэлж байна. Тус сургуульд элсэгчид техникийн чиглэлээр бакалавр, магистр, аспирантурын 135 хөтөлбөрөөс сонгон суралцах эрхтэй ба сургуулиас дээрх хөтөлбөрөөр орос, англи хэлээр

суралцах бэлтгэл ангийг санал болгож байна. ТПИС нь CDIO концепцийг баримтлаж оюутнууд ганцаарчилсан хөтөлбөрөөр орос, англи хэлээр суралцах боломжийг олгож байна. Оюутнууд гадаад хэлний дамжаанд суралцаж TORFL, PET, FCE, CAE, CPE, IELTS зэрэг олон улсын шалгалтыг өгөх боломжтой ба сургуулиас Double-Degree хөтөлбөр болон дэлхийн 21 орны их дээд сургуультай академийн солилцооны хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж байна. ТПИС нь тус сургуульд төлбөргүй болон хөнгөлттэй суралцах боломжийг оюутан залууст олгодог "Орос улсад суралцах цаг!" төсөл болон "Чиний анхны амжилт" олимпиадыг зохион байгуулагч, оролцогч юм. Тус сургуулиас оюутны тохилог дотуур байр, нисэх буудал, галт тэргэний вокзал дээр тосч утгах, визийн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн даатгал хийж өгөх, элсэлтийн бичиг баримтыг бүрдүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх зэрэг олон дэмжлэг туслалцааг гадаад

оюутнуудад үзүүлдэг төдийгүй олон төрлийн стипендийг олгох, эхний семестрийг сургуулийнхаа гадаад түнш сургуульд суралцах боломжоор хангадаг. Оюутнуудын амьжиргааны сарын дундаж өртөг 400-800 рубль; эрүүл мэндийн даатгал – жилийн 55 евро; бүртгүүлэх, нэг жилийн олон удаагийн виз – 25 евро; хоол – сарын 150 евро; унаа – сарын 10-15 евро, ном – жилийн 38-64 евро. Оюутнуудын Томск хотод амьдрах сарын дундаж өртөг 200 орчим евро. Томскийн үндэсний судалгаа шинжилгээний политехникийн их сургуульд суралцах нь ирээдүйн ажил албанд амжилттай хүрэх анхны том алхам юм.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Гадаад оюутнуудтай ажиллах хэлтсийн дарга Буйкин С.В.
Утас: +7 (3822) 60-64-76
Email: buikin@tpu.ru, omrs@tpu.ru
www.iie.tpu.ru, www.tpu.ru



Уральский федеральный университет

имени первого Президента
России Б.Н.Ельцина



Уралын улсын их сургууль нь Уралын эртний их сургуулиуд болох УГТУ-УПИ болон УрГУ-ийн суурин дээр байгуулагдсан. УУИС-д олон талт боловсролын зарчим үйлчилдэг бөгөөд үүнд техник, байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн бүхий л салбаруудыг хамран шинжлэх ухаан, боловсрол, нийгмийн хандлага, инноваци нэвтрүүлэлтийн төв нь болоод байна.

Тус их сургууль нь өнөөдөр дээд боловсролын өргөн хэмжээний хөтөлбөр, олон тооны тэтгэлгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж (2016 онд 7000 гаруйд хүрнэ), үүндээ мөн гадаад оюутнуудыг хамруулж байна. "Эксперт РА" рейтингийн агентлагийн Оросын их дээд сургуулиудын нэр хүндийн судалгаагаар УУИС нь шилдэг 10 их сургуулийн тоонд орж, техникийн болон эдийн засгийн чиглэлийн боловсон хүчин бэлтгэх талаараа Оросын улсын сургуулиудаас манлайлж байна. УУИС нь мөн "Интерфакс" групп, "Эхо Москвы" радиостанцийн рейтингээр топ-15-д орж, QS World University Rankings рейтингийн топ-650, QS: Хөгжиж буй Европ болон Төв Азийн шинэ рейтингэд топ-60-д, QS World University Rankings: BRICS-ын орнуудын их сургуулиудаас 77-р байр, дэлхийн их сургуулиудын шанхайн Академик рейтингэд 500+ (The Academic Ranking of World Universities) байруудад тус тус ороод байна.

УУИС нь чанартай тоног төхөөрөмж, материаллаг баазтай. Сүүлийн хэдэн жилүүдэд их сургууль нь шинжлэх ухааны паркаа шинэчлэхэд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт хийж, одоо энд дэлхийн түвшний судалгаа явуулж, тэтгэлэг авч, олон улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломж бий болоод байна. Одоогийн байдлаар их сургуульд 80 инновацийн аж ахуйн нэгж, 72 дэвшилтэт технологийн төвүүд байгуулагдаад байна.

УУИС нь гадаад харилацаагаа улам өргөжүүлэн өнөөгийн байдлаар 400 гадаадын их сургуулиудтай хамтран ажиллаж олон улсын сүлжээний БРИКС-ийн их сургуулиудын

ОРОСЫН АНХНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.Н.ЕЛЬЦИНЫ НЭРЭМЖИТ УРАЛЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Лиг, ТУХН орнуудын их сургуулиуд, ШХАБ-ын их сургуулиуд, Арктикийн их сургуулиуд, Орос, Хятадын техникийн их сургуулиудын холбоо зэрэг төслүүдэд оролцож байна.

Их сургуулийн оюутнууд өнөөдөр ОХУ-ын Ерөнхийлөгчийн, ОХУ-ын Засгийн газрын, Оросын анхны Ерөнхийлөгч Б.Н.Ельцины, В.Потанины буяны сан, Свердловск мужийн Амбан захирагчийн, Орос-Оксфордын сангийн зэрэг 20 гаруй төрлийн нэрийн тэтгэлэг авч байна.

УУИС-д сурна гэдэг бол) дэлхийн бүхий л орнуудын оюутнуудтай танилцах, урилгаар ирсэн гадаадын профессоруудын шилдэг лекц, семинаруудад суух, сургууль дээр жил бүр зохион байгуулагддаг олон улсын арга хэмжээнүүдэд оролцох боломж юм. Гадаадын эрдэмтэдийн энд ирдэг бас нэг шалтгаан нь тэд өндөр стандартад нийцсэн орчин үеийн техник төхөөрөмжүүд дээр ажиллах боломж байгаа юм.

Өнөөдөр уралын шилдэг их сургуульд 35000 гаруй оюутан суралцаж байгаагаас 24000 нь өдрөөр суралцаж байна. УУИС нь 177 дээд боловсролын мэргэжлийн чиглэл, 7 чиглэлээр дунд мэргэжлийн боловсрол, мөн ур чадвараа нэмэгдүүлэх нэмэлт боловсролын хөтөлбөрүүд, мэргэжлийн дахин бэлтгэл, их сургуулийн элсэлтийн бэлтгэл, MBA-ийн ур чадварын сургалтыг тус тус зохион байгуулж байна.

Их сургуулийн бүтцэд 18 институт (үүнд газрууд болон факультетууд багтдаг), 250 гаруй

УУИС-ын сургалтыг 3697 багш хариуцаж, үүнээс 570 доктор профессор, 1793 нь докторант, доцент байна. Их сургуулийн албан хаагчдаас Оросын шинжлэх ухааны академийн 24 жинхэнэ гишүүн, сурвалжлагч-гишүүн, Оросын зураачдын академийн 2 гишүүн, Оросын болон олон улсын академуудын 110 гишүүд байдаг.

тэнхим, 14 салбар ордог. УУИС-ийн оюутнууд нь 14 сургалтын байруудад сурч, 16 оюутны байруудад амьдарч байна. 2013 оны 12 сард 1000 хүнд зорилсан шинэ дотуур байр ашиглалтанд орсон. Өнөөдрийн байдлаар оюутнуудыг хүлээж авах 6500 орчим хүний байр байна.

Тус их сургуульд дэлхийн 75 орноос 1700 гаруй гадаадын оюутан байгаагаас мөн Монголоос суралцаж байна. Түүнээс гадна их сургууль нь жил бүр 200-с багагүй оюутныг академик солилцоо, олон улсын сургуулиудын хөтөлбөрүүдэд хамруулдаг. Жил бүр УУИС-ийн 500 багш, оюутнууд гадаад руу академик солилцооны хөтөлбөрт хамрагдан их сургуулиас тэтгэлэг авах боломжтой байдаг.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

www.urfu.ru


УУИС-ийн элсэлтийн комисс

И-мэйл: priem@urfu.ru

+7 (343) 375-44-74

Екатеринбург хот, 620002,

Энх тайвны гуд., 19, каб. ГУК-100



ОРОСЫН УЛСЫН УС ЦАГ УУРЫН ИХ СУРГУУЛЬ

Оросын улсын ус цаг уурын их сургууль (РГГМУ) 1931 онд байгуулагдсан. РГГМУ өнөөдөр хавсрага ус цаг уур, далай судлалын салбарт мэргэжилтэн бэлтгэдэг ОХУ-ын цорын ганц их сургууль учраас 1994 онд Бүх дэлхийн цаг уурын байгууллагын олон улсын бүсийн сургалтын төвийн статустай болсон.

1995 оноос хойш 50 гаруй оюутан Бүх дэлхийн цаг уурын байгууллагын тэтгэлгээр суралцан төгссөн бөгөөд манай төгсөгчид улс орныхоо цаг уурын байгууллагуудад удирдах албан тушаалд ажиллаж байна. Бүх дэлхийн цаг уурын байгууллагын тэтгэлгээр манай сургуульд суралцахыг хүсч байгаа бол бидэнтэй marketing@rshu.ru хаягаар холбогдоорой.

Манай сургууль ОХУ-ын хоёр дахь том хот болох Санкт-Петербург хотод байдаг.

РГГМУ нь чиний сургууль бөгөөд хэрвээ хүсвэл:

- Атмосферийн байдлыг шинжлэх, боломжит өөрчлөлтийг нь үнэлэх, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг хийх, хүрээлэн байгаа орчинд болж байгаа үйл явцыг загварчлаж сурах зэргээр байгалийн аюулаас урьдчилан сэргийлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах (сурах мэргэжил: «хавсрага цаг уур судлал», « цаг уурын мэдээлэл-

хэмжих систем», «нисэхийн цаг уур судлал»);

- Гол, нуур, усан санг судлах, усны урасцыг тооцоолох, нутаг дэвсгэрийн усны нөөцийг тодорхойлох, ус судлалын дэглэмийн элементүүдийг урьдчилан мэдээлэх, ус судлалын



судалгаа шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох, нэг үгээр хэлбэл чиний эх оронд цэвэр усны асуудал байгаа бол энэ факультет чинийх! (Сурах мэргэжил: «хавсрага ус судлал»);

- Тэнгисийн гүнийг судлах, дэлхийн далайн бүтэц, шинж чанарыг шинжлэх (сурах мэргэжил: « хавсрага далай судлал»);

- Экологийн экспертиз, мониторингийг хийх, экологийн мэдээллийн баазыг бий болгож хөтлөх, үйлдвэрийн газрын экологийн бодлогыг боловсруулах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбарт удирдлагын системийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх. Дэлхийн экологийг хадгалан хамгаалах чадвар нь өнөөдөр хамгийн хэрэгцээ шаардлагатай мэргэжил болоод байна. (Сурах мэргэжил «экологи ба байгаль ашиглалт», «физик», «усны био нөөц, аквакультура»);

- Орчин үеийн мэдээллийн системийг нэвтрүүлж, ашиглах ажлыг хийх, энэ системийг

мэдээллийн орчинд занал хийх нөхцөлд хамгаалах (сурах мэргэжил «хавсрага мэдээлэл зүй», «бизнес-мэдээлэл зүй»);


- Эдийн засгийн салбарын мэргэжилтэн болох (сурах мэргэжил: «Үйлдвэрийн газар, байгууллагын эдийн засаг»,



«Нягтлан бодох тооцоо»).

Тус сургуульд суралцах чиний хичээл бэлтгэл факультетээс эхэлнэ.

Чамайг манай сургууль урьж байна! Санкт-Петербургийн гадаад оюутны холбоо манай сургууль дээр байдаг юм шүү! Дарга нь манай аспирант!



ХОЛБОГДОХ ХАЯГ:


Нэмэлт мэдээллийг авах хаяг:
marketing@rshu.ru





СЕВЕРО-ВОСТОЧНЫЙ ФЕДЕРАЛЬНЫЙ
УНИВЕРСИТЕТ ИМЕНИ М.К. АММОСОВА

М. К. АММОСОВЫН НЭРЭМЖИТ ЗҮҮН –ХОЙТ ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ



М. К. Аммосовын нэрэмжит ЗХХИС нь (СВФУ) ОХУ-ын тэргүүлэх их сургуулийн нэг бөгөөд холбооны 10 их сургуулийн нэг. Тэрээр ОХУ-ын их дээд сургуулиудын үндэсний рейтингт 32-р байр эзэлдэг(интерфакс), Global World Communicator-ын мэдээллээр дэлхийн ТОП-500 шилдэг их сургуулийн тоонд, QS Rankings – BRICS-ийн ТОП-200-д тус тус ордог.

эмнэлзүй», «Дэлхийн эдийн засаг», «Менежмент», «Хууль», «Барилга», «Нефть хий», «Уул уурхай», «Хавсрага геолог», «Хавсрага математик, информатика», «Радиофизик», «Эколог, байгаль ашиглалт», «Химийн технолог», «Гадаадын бүс нутаг судлал», «Сэтгүүл зүй», «Аялал жуулчлал», «Биолог», «Клиникийн сэтгэл судлал» зэрэг сургалтын олон хөтөлбөр, мэргэжлээр оюутнууд

цаны бааз, оюутны сувилалтай, 20 гаруй спортын секц дугуйлан, соёлын төв ажилладаг. Гадаад оюутнууд ганцаарчлаж ажиллах байнгын дэмжлэгтэй. Оюутны «NEFU International» клуб нь гадаад оюутнуудыг Якутск хотын амьдралд дасан зохицоход дэмжлэг үзүүлж, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх сонирхолтой арга хэмжээнүүдийг зохиодог.

Сургуульд Мамонтын хосгүй гоё музейтэй ба оюутнууд цаг уурын өөрчлөлт, мөнхийн цэвдгийг судалж, якутын азмаазаар алмаазан гоёл чимэглэл хийж сурдаг. Тус сургууль нь өөрийн клиник, шүдний эмнэлэгтэй. Нэмэлт мэдээлэл: Дотуур байрны үнэ нь засгийн газрын тэтгэлгээр суралцагч оюутнуудын хувьд 2-3 ортой өрөө сард 550 рубль, гэрээгээр суралцагч оюутнуудын хувьд сарын 1100 рубль. Эрүүл мэндийн даатгалын үнэ: жилийн 4900 рубль. Сургалтын олон удаагийн визийн өртөг / жил бүр сунгана/: 1600 рубль. Оюутны Якутск хотод амьдрах амжиргааны дундаж өртөг: сарын 15000-20000 рубль.



Тус сургууль нь ОХУ-ын Зүүн-Хойд тойргийн шилдэг их сургууль бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол, Өмнөд Солонгос, Таджикистан, Кыргызстан, Индонезия, Вьетнам, Украина, Афганистан, Перу, Гайана зэрэг улсын 20000 гаруй оюутнууд суралцдаг. «Эмчилгээ», «Шүдний

суралцах дуртай.

Оюутны хотхон нь тохилог дотуур байртай бөгөөд оюутнуудыг орос оюутан, гадаад оюутан гэсэн холимог зарчмаар өрөөнүүдэд суулгадаг. Тус сургууль нь спортын цогцолбор, стадион, усан бассейн,

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Россия, г. Якутск, ул.
Белинского 58

Утас:

+7 (4112) 36-14-53;

+7 (4112) 32-14-81

И-мэйл: international@s-vfu.ru

Веб сайт:

www.s-vfu.ru




ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургууль нь оросын ууган тэргүүлэх их сургуулийн нэг юм. Сургалтын тэргүүний технолог, зарчмын цоо шинэ хичээл хөтөлбөр, өргөн их гадаад харилцаа нь Санхүүгийн их сургуулийн өнөөгийн нүүр царайг тодорхойлж байна. Тус сургуулийн эрдэмтэн багш дотор ОХУ-ын гавьяат эдийн засагч, банк, санхүү, даатгал, аудитын компани, санхүү-аж үйлдвэрийн томоохон байгууллагуудын олон дарга нар ажилладаг.

Гадаадын олон нэртэй эрдэмтэд тус сургуульд байнга лекц уншдаг. Жил бүр Санхүүгийн их сургуулийн олон оюутан Их британи, Герман, АНУ, Франц, Итали, Австри, Хятадын шилдэг их дээд сургуулиудад хос дипломын хөтөлбөрөөр суралцаж байна. Манай шилдэг төгсөгчид болох

олон нэр хүндтэй эдийн засагч, санхүүч, улс төр, нийгмийн нэртэй зүтгэлтнүүд нь Санхүүгийн их сургуулийнхаа онцгой бахархал билээ. Манай олон төгсөгч ОХУ-д төдийгүй дэлхийн олон оронд амжилттай ажиллаж байгаа нь Санхүүгийн их сургууль дэлхийн хамгийн өндөр шаардлагад нийцсэн олон улсын хэмжээний шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэн төгсгөдгийн нотолгоо юм.



СУРГАЛТЫН ҮНЭ:

Хөтөлбөр Рубль/жилийн/
Бакалавр 231 000-407 000
Магистр 308 000-330 000
Аспирант/Докторантура/ 177 000
Зайн сургалт 66 000-154 000

БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР:

Мэргэжил:

Эдийн засаг; Менежмент; Ажлын хамт олныг удирдах; Төрийн болон орон нутгийн удирдлага; Аялал жуулчлал; Хууль; Социологи судлал; Улс төр судлал; Мэдээллийн аюулгүй байдал; Бизнес-информатик; Хавсрага математик и мэдээлэл зүй; Хавсрага мэдээлэл зүй

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР:

Мэргэжил:

Эдийн засаг; Санхүү зээл; Төрийн аудит; Менежмент; Төрийн болон орон нутгийн удирдлага; Хууль; Улс төр судлал; Социологи судлал; Хавсрага математик, мэдээлэл зүй; Хавсрага мэдээлэл зүй; Бизнес-мэдээлэл зүй; Мэдээллийн аюулгүй байдал.

Бүрдүүлэх материал:

Гадаад паспорт; боловсролын баримт бичгийн эх, нотариатаар батлуулсан орос хэл дээрх орчуулга; эмнэлгийн бүх төрлийн эмчид үзүүлсэн эрүүл мэндийн бичиг, нотариатаар батлуулсан орос хэл дээр орчуулсан хувь/сургуульд ирэхээс 3 сарын өмнө эмчид үзүүлсэн байх;/; ДОХ-ын шинжилгээний эх бичиг.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

- Хаяг: Российская Федерация, 125993 (ГСП-3), г. Москва, Ленинградский просп., 49
- Сургууль байгуулагдсан он сар өдөр: 1919 оны гурван сарын 2.
- Факультетийн тоо: 14
- Оюутны тоо: 50 000
- Хөтөлбөрийн тоо: дээд боловсролын 175 хөтөлбөр
- Сургалт явуулдаг хэл: орос, англи
- Нэмэлт зардал: байр сарын 780 – 1 410 рубль,
- Сургалтын материал үнэ төлбөргүй,
- Хоол – сарын 13 500 рубль
- Эрүүл мэндийн даатгал - жилийн 6100 рубль
- Унаа – сарын 380 рубль (метро) + 250 рубль (автобус).
- Сарын дундаж зардал: 18 000 рубль.
- Шаардлагатай хэл: 1. Орос. 2. Англи.
- Магадлан итгэмжлэлийг Холбооны боловсрол, шинжлэх ухааны хяналтын албанаас өгсөн. 2015 оны 6 сарын 29-ний №1360 гэрчилгээтэй.

АСПИРАНТЫН ХӨТӨЛБӨР:

Мэргэжил:

Мэдээллийн аюулгүй байдал; Эдийн засаг; Социологийн ухаан; Хууль; Улс төрийн ухаан, бүс нутаг судлал; Философия, ёс зүй и шашин судлал.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Утас:

+7 (499) 943-94-44,

+7 (499) 943-98-52

И-мэйл: interdec@fa.ru



СИБИРСКИЙ ФЕДЕРАЛЬНЫЙ УНИВЕРСИТЕТ
SIBERIAN FEDERAL UNIVERSITY

СИБИРИЙН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ

Сибирийн холбооны их сургууль / СХИС/ нь **ОХУ-ын ТОП 15 их сургуулийн нэг** бөгөөд 2006 онд Красноярск хотын 4 их сургуулийг нийлүүлэн байгуулсан Холбооны 10 их сургуулийн нэг юм.

Тус сургуульд дотоод гадаадын олон оюутнууд суралцдаг бөгөөд европ, ази, америкийн олон түнш сургуулиудтай эрдэм шинжилгээ, боловсролын хамтарсан олон хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Гадаадын олон зуун оюутан тус сургуульд боловсролын янз бүрийн хөтөлбөр, соёлын солилцооны хөтөлбөрөөр суралцаж байна.

СХИС нь шинжлэх ухааныг боловсрол, инновацтай холбоход ихээхэн анхаарал тавьж, оюутнууддаа эрдэм шинжилгээ, практикийн ажлыг явуулах орчин үеийн тоног төхөөрмж бүхий лаборатори, нөхцлийг бий болгосон.


СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

Мэдээллийн технологи
Геотехнологи
Биотехнологи ба шинэ материал
Евроазийн экосистемийн биогеохими
Биолуминесцент биотехнологи
Олон хэмжүүрт цогц анализ ба дифференциаль тэгшитгэл
Инженерийн физик
Шинэ материалын хими, материал судлал
Экологи, байгаль ашиглалт; цаг уурын өөрчлөлт
Дендрохронологи
Хотын тогтвортой хөгжил
Умартын болон Сибирийн жижиг язгуур ард түмнүүдийн орчин үеийн тулгамдсан асуудлууд
Орос хэл, соёл



ТОО БАРИМТ:

- Байрладаг газар: г. Красноярск, Восточная Сибирь, Россия
- Website: www.sfu-kras.ru
- Байгуулагдсан он: 2006
- Бүрэлдэхүүн сургуулийн тоо: 20
- Ажилтны тоо: 4387
- Багш нарын тоо: 3300
- Оюутны тоо: 36500
- Сургалтын хэлбэр: өдрийн / эчнээ сургалт
- Хөтөлбөр, хугацаа: Бакалаврын хөтөлбөр (4 жил),
- Магистрын хөтөлбөр (жил),
- Аспирантурын хөтөлбөр (3/4 жил),
- Докторантурын хөтөлбөр



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Сибирский федеральный университет
Россия, г. Красноярск 660041 пр. Свободный, 79
Утас: +7 (391) 244-82-13, факс: +7 (391) 244-86-25
И-мэйл: rector@sfu-kras.ru, dia@sfu-kras.ru, vupirova@sfu-kras.ru
www.sfu-kras.ru



ОРОСЫН
БОЛОВСРОЛЫН
ҮЗЭСГЭЛЭН
EXPO 2017



ТУВАГИЙН ИХ СУРГУУЛЬ

ТуИС бол Тыва улсын ардын аж ахуйн салбарууд, боловсрол ба төрийн байгууллагуудын мэргэжилтэн бэлтгэх цорын ганц улсын дээд сургууль юм.

Тус сургуульд суралцах хүсэлтэй хүмүүсийн тоогоороо сибирин бүсэд тэргүүлэх байрыг эзэлдэг /нэг мэргэжил тус бүрт 10-15 хүн өрсөлддөг/.

Сүүлийн жилүүдэд их сургууль материал-техникийн байдлаа сайжруулж, бүрэлдэхүүнээ өндөр мэргэжилтэй боловсон хүчнээр нэмэгдүүлсэн нь хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай шинэ мэргэжлүүдийн ангиудыг тухайлбал: “үйлдвэрлийн эдийн засаг ба удирдлага” “үйлдвэрлэлийн технологи ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулалт”, “гадаад хэл”, “нийгмийн ажил”, “технолог ба бизнес” зэргийг нээхэд тус дэм болсон. Их сургууль 6 сургалтын байртай мөн 6 дотуур байртай.

Их сургуульд үйлдвэрлэл-сургалтын дадлага, эрдэм-шинжилгээний ажил явуулах



суурь дэд бүтцүүд үйл ажиллагаа явуулдаг. Амьтан судлал, экологи, эрдэст бодисын музейнүүд бий. 2009 онд ТуИС-д төв азийн угсаатны зүй, археологи, түүхийн музей нээгдсэн. Байгаль-газар зүйн факультетын дэргэд газар тариалан-био станц, ховор устаж буй ургамалыг үржүүлэх мод үржүүлгийн газар мөн жимс хүнсний ногооны цэцэрлэг ба үржүүлгийн газрууд үйл ажиллагаа явуулдаг. 2009 онд байгаль-газар зүйн факультетын хүлэмж нээгдсэн.

Тувагийн их сургууль дээд боловсрол, мэргэжилтэн, багш нарын мэргэжил дээшлүүлэх салбарт гадаад, дотоод хамтын ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байна. Их сургууль

Төв ба сибирин бүсүүдийн дээд сургуулиудтай эртний, уламжлалт академик, ШУ-аргачлалын харилцаатай.

Мөн гадаадын дээд сургуулиудтай тогтвортой харилцаа тогтоосон: МУИС-ийн Ховдын салбар /Монгол улс/, Хунаны сонгодог их сургууль /БНХАУ/ мөн Хумбольдтын их сургууль /Берлин, Герман/.

ТуИС-ийн урилгаар жил бүр Турк, Монгол, АНУ, БНХАУ-аас тус сургуульд суралцахаар оюутнууд хүрэлцэн ирдэг. Хамтын ажиллагааны хүрээнд лекц уншихаар Европ, Ази, Америкийн эрдэм шинжилгээний төвүүдийн аспирантууд ирцгээдэг.



ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ХОЛБОГДОХ ХАЯГ:

Российская Федерация
Республика Тыва
г. Кызыл
ул. Ленина 3
Утас: +7 (39422) 2-34-40
И-мэйл: intertsu@gmail.com,
oms@tuvsu.ru
Вэбсайт: www.tuvsu.ru



ТУСУР /Томскийн удирдлагын систем ба радиоэлектроникийн их сургууль/ бол Оросын техникийн тэргүүлэх сургуулийн нэг юм. Оюутан бэлтгэх явц нь хамгийн нэн чухал болох радиотехник, цахилгаан ба тооцоолох техник, программчлал, удирдлагын автоматжуулалт ба систем, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал, инноваци, эдийн засаг ба нийгмийн ажил салбаруудад явагддаг. ТУСУР дэлхийн аж ахуй/бизнесийн чиглэлийн 19 их сургуулиудын нэг юм /2013 оны Массачусэтсийн технологийн дээд сургуулийн судалгаагаар/. Их сургуульд 10000 орчим оюутан суралцадагас 2000 нь гадаадынх юм. Оюутнуудад зориулан АНУ, Франц, Япон, Казахстаны их сургуулиудтай хавсарсан Double Degree хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

ТУСУР оросын их сургуулиудын дунд гадаад оюутан ноогдох хувиараа гуравт бичигддэг /олон улсын зэрэглэл "QS University Rankings: EESA 2016/17"/.

ТУСУР "Интернациональчлал"-ын ангиллаар ОХУ-д 10-р байр эзэлдэг /"Интерфакс" агентлагын их сургуулиудийн үндэсний зэрэглэл/.

ХАЯГ:

г.Томск, пр.Ленина, 40,
634050
Утас: +7 (3822) 510-804
И-мэйл: inter@main.tusur.ru
Вэбсайт: <http://www.tusur.ru>,
<http://interedu.tusur.ru>

ТУСУР төгсөгчдийн дундаж цалин бусад ижил төрлийн сургууль төгсөгчдөөс илүү өндөр байдаг /Оросын боловсролын мэдээлэл-тооцоолох төв байгууллагын төвийн мэдээллээр/. Сургуулиа төгссөнний дараа төгсөгчдийн 85% нь ажлын байртай болдог.

Орост анх удаа ТУСУР-д оюутны бизнес-инкубаторыг нээсэн ба тэр нь оросын шилдэг 3-т орсон байдаг.

Мөн энд алсын зайны сургалтын томоохон төв ажилладаг.

2016-2017 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр:

- Бакалавр ба магистрын сургалтын хөтөлбөр – 80 000-аас 127 000 хүртэл рубль.;
- Аспирантурын сургалт – 70 000 рублиас.

Орос хэлний түвшин хангалтгүй гадаадын оюутнуудад орос хэлний курс буюу бэлтгэл факультетэд нэг жил сурах боломжтой. Сургалт техникийн ба эдийн засгийн гэсэн хоёр чиглэлээр явагдана.

ТУСУР гадаад оюутнуудад тохилог хямд дотуур байраар хангана /сард 400 рубль/. ГАДААД ОЮУТАНУУДЫГ амжилттай ДАСАН ЗОХИЦУУЛАХАД ЗОРИУЛЖ их сургууль дээр монголын соёлын төвийн нээсэн. ТУСУР-д олон төрлийн спортын секцүүд

ТУСУР-ийн Факультетууд:

- Радиотехникийн факультет
- Радиоконструкторын факультет
- Тооцоолох системийн факультет
- Удирдлагын системийн факультет
- Электрон техникийн факультет
- Инноваци технологийн факультет
- Эдийн засгийн факультет
- Хүмүүнлэгийн факультет
- Хуулийн факультет
- Аюулгүй байдлын факультет
- Алсын зайны сургалтын факультет.

ажилладаг: сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг гэх мэт. Сургалтын байранд оюутны зоогийн газар үйл ажиллагаа явуулдаг /өдрийн хоолны үнэ дундажаар 100 рубль байна.

Томск хот бол сибирийн томоохон ШУ, боловсролын төв юм. Томск анхаарал татах, боломж, аюулгүй байдал ба тохилог байдлаараа Москва, Санкт-Петербург хотуудын дараа гуравт, санхүүгийн боломжит түвшингөөрөө нэгт ордог /QS зэрэглэлийн агентлагийн өгөгдлийн дагуу/. Өнөөдөр Томск 9 дээд сургууль, 11 эрдэм шинжилгээний хүрээлэн, техник-нэвтрүүлэх онцгой эдийн засгийн бүс бөгөөд 6 бизнес-инкубатор, олон тооны лаборатори, зохион бүтээх товчоо үйл ажиллагаа явуулдаг.





САНКТ-ПЕТЕРБУРГИЙН УУЛ УУРХАЙН ИХ СУРГУУЛЬ

Санкт-Петербургийн уул уурхайн их сургууль нь нэгдүгээр Петр хаан, М. В. Ломоносов хоёрын уул уурхайн үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний мэргэжилтэн бэлтгэх тухай үзэл санааны биелэл болж 1773 онд хоёрдугаар Екатерина эзэн хааны зарлигаар байгуулагдсан оросын анхны техникийн дээд сургууль юм.

Уул уурхайн их сургууль нь ОХУ-ын ард түмнүүдийн соёлын өвийн онцгой үнэт объектийн статустай (ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1996 оны 7 сарын 30-ны № 1112 тоот зарлиг) юм.

2009 оноос манай сургууль ОХУ-ын үндэсний судалгаа шинжилгээний их сургуулийн тоонд орсон ба QS World University Rankings by Subject-ний дагуу «Уул уурхай, ашигт малтмал (Mineral and Mining Engineering)» чиглэлээр дэлхийн ТОП-100 их сургуулийн тоонд орон, 58-р байрыг эзэллээ.

Уул уурхайн их сургууль нь дэлхийд нэртэй олон арван эрдэмтдийг төрүүлэн гаргасан. Академич А.П. Карпинский, Е.С. Федоров, В.А. Обручев, Н.С. Курнаков, Н.Г. Келль, Д.В. Наливкин, И.М. Губкин, А.П. Герман, А.А. Скочинский, зөгнөлт зохиолч И.А. Ефремов зэрэг олон төгсөгч эрдэмтэн суутгын дэлхий даяар сайн мэддэг юм.

Манай сургуулийг төгсөгчдийн дотор дэлхийн улс орны төр засгийн тэргүүнүүд ч бий. Эдгээр нь ОХУ-ын Ерөнхийлөгч Путин В.В. (Эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн, 1997 он), Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат (уул уурхайн инженер, 1965 он; эдийн засгийн ухааны доктор, 1999 он.), Бүгд Найрамдах Таджикистан Улсын анхны Ерөнхийлөгч Махкамов К.М. (уул уурхайн инженер, 1953 он) нар юм.

Манай сургуулийн уул уурхайн музей нь 240000 гаруй хосгүй үзвэртэй бөгөөд эдгээр нь дэлхийн 80

орноос авчирч 4000 гаруй кв.м талбай бүхий 20 танхимд байрлуулсан үзвэрүүд бөгөөд байгалийн шинжлэх ухааны чиглэлийн дэлхийн шилдэг гурван музейн нэгд тооцогддог юм.

Уул уурхайн сургуулийн XV-XIX зууны 1,2 сая гаруй ном шинжлэх ухаан-техникийн баялаг номын сан нь орчин үеийн компьютерийн техник, цахим каталогтой.

Уул уурхайн их сургууль нь дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй сайхан хотын нэг болох Санкт-Петербург хотод байдаг ба түүний түүхэн төв болох Василевийн арал дээр оршдог. Энд хичээлийн корпус, орчин үеийн тохилог оюутны байрнь бие биеээс холгой байрладаг.

Өнөөдөр дэлхийн 70 гаруй орны 9000 гаруй оюутнууд манай сургуульд сурч байна. Сургууль дорх мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж



байна. Үүнд: «Ховор барилга, байгууламжийг барих», «Хавсрага геодез», «Хавсрага геолог», «Геолог хайгуулын технолог», «Уул уурхай», «Эколог, байгаль ашиглалт», «Барилга», «Информатик, тооцоолон бодох техник», «Мэдээллийн систем, технолог», «Электроника и нанoeлектроника, «Багаж хэрэгслийн үйлдвэрлэл», «Дулааны эрчим хүч, дулааны техник», «Цахилгаан эрчим хүч, цахилгаан техник», «Машин үйлдвэрлэл», «Технологийн машин, тоног төхөөрөмж»,

«Технологический процесс, үйлдвэрлэлийг автоматжуулах», «Химийн технолог», «Техносферийн аюулгүй байдал», «Нефть хийн үйлдвэрлэл», «Газар зохион байгуулалт, кадастры», «Материал судлал, материалын технолог», «Хар төмөрлөгийн үйлдвэрлэл», «Тээврийн процессийн технолог», «Тээвэр-технологийн машин, комплексийн ашиглалт», «Системт анализ, удирдлага», «Эдийн засаг», «Менежмент», «Материалыг уран сайхны аргаар боловсруулах технолог».

Уул уурхайн их сургууль нь спортын хоёр том цогцолбор, усан бассейн, спортын эрүүлжүүлэх бааз, спортын "Горняк" клубтэй бөгөөд энд спортын олон төрлөөр 25 секц дугуйлан ажилладаг. Оюутны дотуур байр бүр гуанз, тренажерын заал, угаалгын газартай. Гадаадын



оюутнууд амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, уулзалт хурал цуглаан хийх, шинэ жил, үндэснийхээ баяр наадмаа тэмдэглэх Интернационалч найрамдлын клубтэй.

Монгол оюутнууд сард 12000-15000 рублийн дундаж зарлагатай гэсэн статистик тооцоо бий.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Гадаад оюутнуудтай ажиллах деканатын газар: Утас: +7 (812) 328-82-55; 328-86-42.

www.spmi.ru Эл. почта: for-eign@spmi.ru

Хаяг: дом 2, 21 линия, Санкт-Петербург, 199106, Россия.



АЛС ДОРНОДЫН ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ

Алс дорнодын холбооны их сургууль бол оросын алс дорнодын томоохон дээд сургууль бөгөөд Ази-номхон далайн бүсийн академик суурь газар юм. Олон жилийн ШУ-ны уламжлалыг хадгалан, орчин цагийн боловсролын чиг шугамыг анхааран бид Ази-номхон далайн бүсийн эрдэм шинжилгээний төв болохыг эрмэлзэж байна.


Русский арал дээр төвлөрүүлсэн их сургуулийн хотхонд олон улсын боловсролын хөтөлбөр ба эрдэм шинжилгээний судалгаа явуулах, орчин үеийн өвөрмөц тоног төхөөрөмж, орчин үеийн сургалтын технологи эзэмшсэн дэлхийд нэртэй эрдэмтэн, багш нарын оролцуулсан нөхцөлийг бүрдүүлсэн нь шинэ сэдэлт бүхий үеийг хүмүүжүүлж, сургах боломжтой юм.

Алс дорнодын холбооны их сургуулийн шинэ оюутны хотхон бол оросын тэргүүнийх бөгөөд дэлхийд ч тэргүүлдэг юм. Сургууль Номхон далайн эрэгт,



2016/2017 оны хичээлийн жилээс АДХИС бакалаврыг сургалтын "Боловсрол 2.0" шинэ загвараар явуулж эхэлсэн. Эх орны боловсрол дахь энэ гайхалтай төсөл өөртөө дэлхийн практикийг шилдэгийг шингээсэн нь дэлхийн шилдэг дээд сургуулиудийн сургалтыг нэгтгэж өгсөн төсөл юм.

Улс орны удирдлагуудын баталсан АДХИС-ийн стратегийн баримжаа бүрэн тогтворжсон. Их сургууль өөрийн хөгжлийн шинэ шатандаа орж байгаа, тэр зорилго бол - АДХИС-ийг алс дорнодын боловсрол, судалгаа, инновацийн өөртөө чадварлаг залуучууд, шилдэг эрдэмтэд, өндөр технологийн бизнесийг оросоос



Владивосток хотын ойролцоох экологийн цэвэр бүхий Русский арал дээр байрладаг. энэ бол жинхэнэ оюутны смарт хотхон юм: тохилог, гэгээлэг, зочломтгой мөн аюулгүй. Өнөөдөр их сургуульд 52 орны 3200 гаруй оюутан суралцдаг бөгөөд үүний улмаас давтагдашгүй олон соёлт нөхцөл бүрдсэн.

АДХИС бүтцэд 150 технологийн хувьсал хийх ирээдүйн чиг бүхий боловсролын хөтөлбөртэй 9 сургууль багтдаг: Инженерийн сургууль, биоэмнэлэг зүйн сургууль, байгалийн шинжлэлийн сургууль, Дорнодын дээд сургууль - бүс нутаг ба олон улсын судалгааны сургууль, Хуулийн сургууль, Эдийн засаг менежментийн сургууль, Хүмүүнлэгийн ШУ-ны сургууль, Урлаг, соёл, спортын сургууль мөн Сурган хүмүүжүүлэхийн сургууль.

ба гадаадаас татсан томоохон төв болгох явдал юм.

Бид хамтарсан хүчээр үүнд хүрч чадна. АДХИС-д тавтай морилно уу!

Холбоо барих:

Дальневосточный федеральный университет
Отдел привлечения иностранных студентов
690922, Россия, Владивосток, остров Русский,
бухта Аякс, 10, корпус В, кабинет В649

И-мэйл: interadmission@dvfu.ru

Утас: +7 (423) 265 24 24*2206

Whatsapp, viber, telegram +7 914 653 6070

Skype [fevu.admission](https://www.dvfu.ru/admission/pk2017.php)

Вебсайт: <https://www.dvfu.ru/admission/pk2017.php>

www.facebook.com/fevu.admission



NATIONAL RESEARCH
UNIVERSITY

НИУ ВШЭ - Эдийн засгийн дээд сургууль нь ОХУ-ын тэргүүлэх дээд сургуулиудын нэг бөгөөд нийгэм-эдийн засаг, хүмүүнлэг, физик-математик, компьютер, инженерийн шинжлэх ухаан болон харилцаа, дизайны салбарын эрдэм-шинжилгээ, боловсрол, төсөл, шинжилгээ, консалтингийн төв юм. ЭЗДС(ВШЭ) нь 25 жил ажиллах хугацаандаа ОХУ-ын хамгийн нэр хүндтэй экспертийн төвийн түвшинд хүрч, 2009 онд үндэсний судалгаа шинжилгээний их сургуулийн статустай болон дэлхийн академийн хамтын нийгэмлэгийн нэг хэсэг, их дээд сургуулиудын даяаршсан хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч нь болж чадсан юм.

Манай сургууль бол эрдэмтэн, багш ажилтнууд болон дэлхийн 50 гаруй орны оюутан, аспирантуудыг нэгтгэсэн шинжлэх ухаан, боловсролын олон улсын хамгийн өндөр стандартыг хангахыг эрмэлзэж байдаг хамт олон юм. Өөрийн үйл ажиллагааныхаа бүх чиглэлээр даяаршлалын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухаан, боловсрол, төслийн ажлын түвшинг авч явах нь манай стратеги зорилт юм.

Өнөөдөр ЭЗДС нь эрчимтэй хөгжиж байгаа их сургууль



НИУ ВШЭ ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ



бөгөөд манай сургуульд ОХУ-ын болон гадаадын олон орны иргэд суралцаж байна. Манай сургууль эх орны боловсролын шилдэг уламжлалыг дэлхийн шилдэг багшлах практиктай амжилттай хослуулан ажиллаж байгаа бөгөөд бакалавраас аспирантур, мэргэжлийн нэмэлт боловсрол хүртэлх олон тооны хөтөлбөрийг гадаадын олон хэл дээр санал болгож байна. Дээд боловсролын бүх шатны эдгээр хөтөлбөрүүдийг манай сургуулийн тэргүүлэх институт, эрдэм шинжилгээний төвүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлж байгаа болно.

Бид бакалавр, магистр, аспирантур болон мэргэжлийн нэмэлт боловсролын(MBA, DBA хөтөлбөрийг оролцуулан) хөтөлбөрөөр суралцахыг хүсэгч гадаадын иргэдэд зориулсан сургалтыг Москва, Санкт-Петербург, Нижний Новгород, Перми хот дахь оюутны хотхондоо явуулахаар санал болгож байна. ЭЗДС нь 51 орны 242 гадаад түнштэй бөгөөд хамтран ажиллах болон оюутан солилцооны 360 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнээс гадна гадаад горилогчид нь визийн дэмжлэг болон оюутны тохиолол байраар хангагдсан.

Бид оросын олон олон улсын чансаагаар тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа ба QS-ийн 8 зүйлчлэх чансаанд орж(олон улсын хараат бус чансаа), "Социолог судлал", "Эдийн засаг, эконометрик",



"Бизнес ба менежмент", "Нягтлан бодох бүртгэл, санхүү" гэсэн 4 зүйлчлэлээр ОХУ-ын их дээд сургуулиудын дунд тэргүүлэх байрыг эзэлж, 50 хүртэлх настай залуу их дээд сургуулиудын чансаанд дэлхийн топ 60 их сургуулийн тоонд орж байдаг юм.

ЭЗДС нь инновацийн хөгжил болон оросын эдийн засгийн шинэчлэлд ихээхэн практик хувь нэмрийг оруулж байгаа ба манай сургуульд инновацийг хөгжүүлэх олон шатлалт дэд бүтэц бүрэлдэн бий болсон.

ЭЗДС-д оюутны олон үеийн дэмжлэгийг хүлээсэн төслүүд хэрэгжиж байгаа бөгөөд оюутан залуусын өөрсдийн зохион байгуулдаг болон тэдэнд зориулсан олон арга хэмжээ зохиогддог ба эдгээр арга хэмжээнүүдэд манай сургуульд суралцагч оюутнууд төдийгүй тэдний эцэг эх, төгсөгчид, олон хот орон нутгийн иргэд оролцдог.



ХОЛБОГДОХ ХАЯГ:
HSE International Admissions
И-мэйл: inter@hse.ru
Утас: +7 495 531 00 59



МОСКОВСКИЙ
ГОСУДАРСТВЕННЫЙ
ПСИХОЛОГО-
ПЕДАГОГИЧЕСКИЙ
УНИВЕРСИТЕТ

ФГБОУ ВО «МОСКВАГИЙН СЭТГЭЛ ЗҮЙ-СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААНЫ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ»

МУСЗСИС бол орос дахь анхны сэтгэл зүйн чиглэлийн их сургууль юм. Тус сургууль нь өнөөдөр улс орны нэр хүнд бүхий их сургууль гэдэг нь түүнд орох өрсөлдөгчдийн тоо өндөр ба төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд ихээхэн хэрэгцээтэй байдагаар харагддаг юм. 2017 онд МУСЗСИС "Россия сегодня" агентлагийн үзүүлэлтээр хүмүүнлэгийн сургуулиудын дунд нэгдүгээр байр эзэлсэн.

МУСЗСИС-д 12 факультетэд 5000 гаруй оюутан суралцдаг: боловсролын сэтгэл зүй, нийгмийн сэтгэл зүй, зөвлөх ба клиник сэтгэл зүй, клиник ба тусгай сэтгэл зүй, хуулийн сэтгэл зүй, эрсдэлт сэтгэл зүй, улсын ба хотын удирдлага, гадаад хэл, мэдээллийн технологи, нийгмийн харилцаа холбоо, нийгмийн сурган хүмүүжүүлэх ухаан, алсын сургалтын факультет.

Их сургуульд гадаадын оюутан суралцах үр дүнтэй нөхцөл бүрдсэн. Ойр болон алсын гадаад орнуудтай академик солилцооны хөтөлбөрүүд нээлттэй. Олон улсын магистрын хөтөлбөр, мөн хоёр диплом олгох хөтөлбөрүүд Болгар, Итали мөн Германтай хэрэгжүүлдэг. ЮНЕСКО-ийн "хүүхэд насны соёл-түүхийн сэтгэл зүй" кафедрт олон улсын судалгааны магистрын "Соёл-түүхийн сэтгэл зүй ба боловсролд идэвхтэй хандах нь" гэдэг хөтөлбөр нээгдсэн бөгөөд энд энэ салбарын дэлхийн нэр бүхий профессор - судлаач нар Австрали, Болгар, Их британи, Герман, Грек, Итали, Литв, Финлянд ба Швейцариас ирж хичээл заадаг.

Одоо их сургууль Москва хотын сэтгэл зүйн төв албаны бааз болсон бөгөөд боловсролын байгууллагуудын сэтгэл зүйчдийн ажлыг зохицуулдаг ба нийгмийн салбарт янз бүрийн мэргэжлийн үйл ажиллагааны мэргэжилтний бэлтгэлийг хэрэгжүүлдэг / мөн эрсдэлтэй, онцгой байдлын ажлууд/. Их сургуульд хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд суралцах тохитой нөхцлийг бүрдүүлсэн.

Их сургууль орос ба гадаад хэл дээрх бүрэн текст бүхий эх сурвалжуудын суурь цахим номын сантай.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Их сургуулийн вэбсайт: <http://mgppu.pf>
Хаяг: 127051, Российская Федерация, г. Москва,
ул. Сретенка, д. 29
Утас: +7(495)632-90-77; +7(495)607-08-72
И-мэйл: rectorat@list.ru; oia.mgppu@gmail.com

Номын сан цахим хэлбэрийн сургалтын материал ба ховор сэтгэл зүйн хэвлэлүүдтэй танилцах боломжийг олгодог.

Оюутны нухацтай сургалт практик-чиглэл хандлагатай хосолдог. Оюутнууд сургалтын явцад практик ажлын туршлагыг сэтгэл зүйн төвд, эрдэм шинжилгээний лабораторид мөн ердийн сургалтын байгууллагуудад олж авдаг. Их сургуулийн иж бүрдэлд нийт 593 практикийн бааз мөн 9 эрдэм шинжилгээний төв байдаг.

Их сургууль олон улсын ISO 9001:2008 стандартын шаардлага, мөн олон улсын нэгдсэн IQNet жишгийг хангасан менежментийн чанарын системийн дагуу ажилладаг.

МУСЗСИС нь дунд сургууль төгсөгчдийг дээд боловсролын чиглэлээр суралцахыг урьж байна: сэтгэл зүй, сэтгэл зүй-сургану ухааны боловсрол, залуучуудтай ажиллахыг зохион байгуулах, нийгмийн ажил, хэл зүй, хавсрага мэдээлэл зүй, математик хангамж мөн мэдээллийн системийн нэгтгэл, тусгай боловсрол /согогтой хүүхдийн судлал/.





ОРОСЫН
БОЛОВСРОЛЫН
ҮЗЭСГЭЛЭН
EXPO 2017



УРАЛЫН УЛСЫН ХУУЛИЙН ИХ СУРГУУЛЬ

УУХИС 1918 онд байгуулагдсан цагаасаа хойш зуу гаруй жил турш оросын болон гадаадын ажил олгогч нарт хуулийн өндөр мэргэшилтэй боловсон хүчинг бэлтгэж байна.

Манай их сургуулийг ажил олгогч нар өндрөөр үнэлдэг бөгөөд төрийн удирдлагын элит төлөөлөгчдийн боловсролын зэрэглэлээр 2014 онд оросын их дээд сургуулийн дунд О.Е.Кутафины нэрэмжит МУХА мөн ОХУ-ын ГЯ-ны Олон улсын харилцааны дээд сургуультай хамт 3-р байрыг эзэлсэн юм.

Манай сургуулийн бүрэлдэхүүнд 5 дээд сургууль багтдаг: Прокурорын дээд сургууль, Хууль зүйн дээд сургууль, Улсын ба олон улсын эрх зүйн дээд сургууль, Эрх зүй, үйлдвэрлэл эрхлэлтийн дээд сургууль, түргэвчилсэн ба эчнээ сургалтын дээд сургууль; оройн факультет, нэмэлт боловсролын факультетээс гадна 24 тэнхим ажилладаг. Их сургууль бакалаврын хөтөлбөр, "Үндэсний аюулгүй байдлыг эрх зүйн хувьд хангах" тусгай мэргэжлээр болон магистрын 20 хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

УУХИС-ийн сургалт олон улсын түвшин рүү чиглэсэн бөгөөд мэдээллийн технологи, оросын болон олон улсын боловсролын стандартын дагуу явагддаг. Манай сургууль хуулийн мэргэжилтэн



бэлтгэхэд гадаадын их дээд сургуулиудтай үр бүтээлтэй хамтран ажиллаж байна.

УУХИС-ийн төгсөгчдийн 95% хууль хяналтын байгууллага, шүүх, өмчийн бүх хэлбэрийн байгууллага, үйлдвэр, өмгөөлөл, нотариат, банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалтын салбарт амжилттай ажиллаж байна.

УУХИС олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд жил болгон оюутан, багш нар олон улсын форум, бага хурал, уралдаан, семинаруудад оролцдог төдийгүй сургууль маань өөрөө олон улсын ийм арга хэмжээний талбар болдог.

УУХИС нь гадаадын боловсролын байгууллагуудтай хоёр талын хамтын ажиллагаагааг идэвхтэй хөгжүүлж байна. Бид их ажилладаг, бие даасан шийдвэр гаргадаг, хариуцлагыг өөртөө хүлээн авдаг, өвөрмөцөөр сэтгэдэг, харилцаа сайтай, амжилтанд тэмүүлсэн хүмүүстэй хамтран ажиллах сонирхолтой.

Өдрийн ангийн сургалтын төлбөр нэг семестрт 1184 америк доллар, өдөр-эчнээ сургалтын нэг семестр 629 америк доллар, эчнээ сургалтын нэг семестрийн төлбөр 502 америк доллар тус тус байна.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Элсэгчдийг хүлээн авах сектор
Хаяг: 620137, г. Екатеринбург, ул. Комсомольская, д. 21, каб. 109
Утас: (343)374-40-33),
Email: pk@usla.ru
Вэбсайт: <http://www.usla.ru/>




ӨМНӨД ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ



БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ :

- Академик солилцооны хүрээн дэх модуль сургалт (нанотехнологи, шинэ материал, дэлхийн шинжлэх ухаан);
 - Хичээл хоорондын модули (хүмүүнлэгийн ухаан, социологи судлал, эдийн засаг, олон улсын харилцаа, хэл шинжлэл);
 - Европын инновацийн их сургуулиудын консорциумын түнш сургуулиудтай хамтран хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд (биомеханика, европын судалгаа шинжилгээ, компьютерийн ухаан);
 - Англи хэл дээр хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд;
 - Зун, өвлийн сургууль ;
 - Орос хэлний дамжаа;
 - Хар далайн бүс нутгийг сэргээн хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр;
 - Азово-хар далайн бүс нутгийн инновацийн болон соёлын экосистемийн асуудлаарх боловсролын хосгүй хөтөлбөр(усны нөөц, менежмент, хөрс судлал, угсаатны зүй г.м..).
- Нийгмийн дэд бүтэц:
- Дон дахь ростов хотод байх оюутны 9 дотуур байр;
 - Таганрог хотод байх оюутны 7 дотуур байр;
 - Нийт талбай: 229 470 м²;
 - Дотуур байрны орны тоо - 6 000 гаруй ;
 - 8 627,1 М² талбай бүхий усан бассейн .



Өмнөд Холбооны их сургууль /ӨХИС/ нь ОХУ-ын Өмнөд бүсийн хамгийн том шинжлэх ухаан-боловсролын төв юм. Тэрээр Дон дахь Ростов, Таганрог хотод Эзэн хааны Варшавын их сургууль нүүн ирсэн 1915 оноос өөрийн түүхээ эхэлдэг. Энэ нь тус сургуулийн цар хүрээг тодорхойлж, сайн чанарын мэргэжилтэн бэлтгэдэг их сургууль болох, суурь болон хавсрага судалгааг хөгжүүлэх, олон улсын боловсролын сүлжээнд хамрагдах зэрэг шийдвэрлэх олон асуудлаас үүдсэн нүүн шилжилт байв.

Тус сургуулийн стратеги зорилго нь шинэ мэдлэгийг үйлдвэрлэхэд идэвхтэй оролцох, түүнийг дэлгэрүүлэх, шинжлэх ухаан, боловсрол, инновацийн үйл ажиллагаар дамжуулан ашиглах, нийгмийн ёс суртахуун, соёлын үнэт зүйлсийг хуримтлуулан аливжуулах, бүх оросын, бүс нутаг, олон улсын боловсрол, шинжлэх ухаан, соёлын томоохон төвийг бий болгох, дэлхийн шилдэг их сургуулийн тоонд орох явдал юм.

Өнөөдөр ӨХИС нь улс орныхоо эрдэм шинжилгээний судалгаа шинжилгээ, боловсрол, инновацийн үйл ажиллагаанд өөрийн тэргүүлэх үүрэг болон дэлхийн тэргүүлэх их сургуулиудын сүлжээнд эрх тэгшээр бүрэн дүүрэн оролцон ажиллагаа өөрийн үйл ажиллагаараа нотолж байна.

Тус сургуулиас олгодог чанартай боловсрол нь боловсролыг шинжлэх ухаантай холбох суурь бэлтгэл, интеграцийг хангаж байна.

ӨХИС нь олон улсын хамтын ажиллагаагаараа оросын их дээд сургуулиудын дунд тэргүүлэх байрыг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд тус сургуулийн гадаад хамтын ажиллагаа, тухайлбал мэдээлэл хангамжийн гадаад хамтын ажиллагаа идэвхжиж, боловсролын академик хөдөлгөөнт чанарын эерэг динамик үзүүлэлт дээшилж, гадаад оюутан болон европын нэр хүндтэй олон улсын хөтөлбөрийн тоо өслөө.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Южный федеральный университет
Россия, г. Ростов-на-Дону, ул.
Большая Садовая, 105/42
Утас: +7 (863) 218-40-00
И-мэйл: info@sfedu.ru
Сайт: http://sfedu.ru



АДЫГЕЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Холбооны улсын дээд боловсролын төсвийн байгууллага «Адыгейн улсын их сургууль».

Адыгейн улсын их сургууль нь 1940 онд байгуулагдсан ба Адыгейн Бүгд найрамдах улсын сургалт-эрдэм шинжилгээний гол төв бөгөөд 2015 оны 10 дугаар сард 75 жилийнхээ ойг тэмдэглэсэн.

Тус сургуулийн ректор нь социологийн ухаан доктор профессор Рашид Думаличевич Хунагов.

Адыгейн улсын их сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл орчин үеийн сонгодог их сургуулийн гол гурван үүрэг болох боловсрол, шинжлэх ухаан, бүс нутгийн хөгжлийг хангахад оролцож байна.

Тус сургуульд 11000 гаруй дотоод гадаадын оюутан залуус мэргэжлийн боловсролын олон чиглэлээр суралцаж байна.

Адыгейн улсын их сургуулийн бүрэлдэхүүнд 2 дээд сургууль (Урлагийн дээд сургууль, Биеийн тамир жүдогийн дээд сургууль), 12 факультет (математик, компьютерийн ухаан, инженерийн физик, байгаль судлал, түүх, хэл шинжлэл, адыгейн хэл, соёл судлал, гадаад хэл, хууль, эдийн засаг, сурган хүмүүжүүлэх, нийгмийн технологи,



аялал жуулчлал, олон улсын), хүмүүнлэг-техникийн коллеж, цогц асуудлын эрдэм шинжилгээний институт, эрдэм шинжилгээний төв, лаборатори, музей, Улсын сансрын үйлчилгээний төв, оюутны бизнес-инкубатор, мэргэжил-бэлтгэлийн төв тус тус ажилладаг.

Тус сургууль ниймийн хөгжингүй дэд бүтэц, сувилал, спортын ордон, амралтын бааз болон соёлын бусад чиглэлийн салбаруудтай.

Өнөөдөр Адыгейн улсын их сургуульд Азербайджан, Бангладеш, Египт, Энэтхэг, Иордани, Ирак, Хятад, Ливан, Литв, Молдов, Монгол, Нигери, Чад, Сири, Таджикистан, Туркменистан, Туркээс ирсэн 1000 гаруй оюутан залуус суралцаж байна.

Тус сургууль Монголын Боловсролын их сургуультай нягт хамтран ажилладаг.

2016 оны 11 сард тус сургуульд Монгол улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Банзрагчийн Дэлгэрмаа зочилж сургуулиас мэргэжилтэн бэлтгэх ажилд өндөр үнэлэлт өгсөн.

Сургуулийн олон улсын факультет гадаад оюутны асуудлыг хариуцаж, мэргэжлийн чиглэлээр суралцах хичээл сургуулийг зохион

явуулдаг. Мөн энэ факультетийн үндсэн зорилгод олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын академик солилцоог өргөжүүлэх, инновац хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх асуудлуудын зэрэгцээ гадаадын оюутнуудыг Адыгейн улсын их сургууль болон ОХУ-ын бусад их дээд сургууль, коллежид суралцахад бэлтгэх үндсэн зорилго багтдаг.

Тус сургуульд орос хэлний бакалавр, магистр багш бэлтгэн төгсгөдгийг тэмдэглэн хэлэх хэрэгтэй.

Наши выпускники, поступившие в другие вузы России, не теряют связи с АГУ и выражают признательность за полученные знания о русском языке и русской культуре. В связи с этим организован клуб выпускников «АГУ – НАШ ОБЩИЙ ДОМ» Манай сургуулийг төгсөгчид ОХУ-ын бусад их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцахдаа төгссөн сургуультайгаа үргэлж холбоотой байж, орос хэл, соёлын мэдлэг олгосон сургуулиа үргэлж талархан дурсдаг. Иймээс ч төгсөгчдийн “АДЫГЕЙН ИХ СУРГУУЛЬ БИДНИЙ НИЙТЛЭГ ГЭР ОРОН” клуб байгуулагдсан.

Адыгейн их сургууль нь та бүхний намтрын яруу тод хуудас болж, эх орондоо ажил амьдралынхаа амжилтай гарааг эхлүүлэх сургууль байж чадна.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 385000 Россия, республика Адыгея, г. Майкоп, ул. Первомайская 208
Утас/факс: +7 (8772) 59-37-52
И-мэйл: tsusanna@mail.ru

ОРОСЫН УЛС ТҮМНИЙ НАЙРАМДЛЫН ИХ СУРГУУЛЬ



RUDN
university

Оросын улс түмний найрамдлын их сургууль нь (РУДН) 1960 онд ЗСБНХУ-ын Засгийн газрын тусгай тогтоолоор «Патрис Лумумбын нэрэмжит улс түмний найрамдлын их сургууль» нэртэйгээр байгуулагдсан. Тус сургуулийн 90000 гаруй мянган төгсөгч дэлхийн бараг бүх оронд ажиллаж байна. Тэдгээрийн дотор олон төрийн тэргүүн, ерөнхий сайд, сайд, улс төрч, бизнесмен, эрдэмтэн, соёлын зүтгэлтнүүд байдаг юм.

Оюутнууд спортын олон төрлөөр үнэгүй хичээллэх спортзал, талбайтай. Суралцах болон оюутнууд хоорондоо харилцах хэл нь – орос хэл. Орос хэлгүй гадаад оюутнууд эхний жил орос хэлний факультетэд орос хэлийг судалдаг.



Тус их сургуульд 1 академи, 7 факультет, 10 институт, 156 шинжлэх ухаан-боловсролын лаборатори, хамт олноороо ашиглах 4 төв ажилладаг ба бакалавр, магистрын 18 хөтөлбөр олон улсын магадлан итгэмжлэлийг авсан. 2500 эрдэмтэн профессор, доцент багш нар тус сургуульд ажилладаг.

Эрдэм шинжилгээ-судалгааны олон төв, лабораториудад шинжлэх ухаан-судалгааны ажлыг явуулдаг ба тус сургуулийн математик, хими, анагаах ухаан, хэл шинжлэлийн салбар сургуулиуд их хүчирхэг.

Тус сургуульд 28000 оюутан суралцдагаас дэлхийн 152 орноос ирсэн 7000 орчим гадаад оюутан мөн суралцдаг. Гадаад оюутнууд улс уцлсынхаа өөрсдийн зөвлөлүүдтэй.

Москва хотын захиргаа Улс

түмний найрамдлын их сургуулийн оюутны хотхоныг Москвагийн шилдэг оюутны хотхоноор шалгаруулсан ба тус оюутны хотхон нь бүх оросын «Оюутны шилдэг дотуур байрны төлөө» уралдаанд түрүүлсэн юм.

Тус сургууль оюутны 13 дотуур байртай бөгөөд эдгээр байранд угаалгын газар, хими цэвэрлэгээ, хувцас засварын газар, гоо сайхны салон, олон үндэстний хоолтой гуназ, кафе ажилладаг. Оюутны амжиргааны өртөг нь ахуйн үйлчилгээний өртгийг оролцуулаад жилд 980-3500 доллар байдаг.

Улс түмний найрамдлын их сургуулийн анагаах ухааны сургуулийн клиник-оношлогооны төв болон эмчилгээ-урьдчилан сэргийлэх байгуулага сургуулийнхаа нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг. Оюутны эрүүл мэндийн даатгалын жилийн үнэ 300 доллар.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

117198, Москва, ул. Миклухо-Маклая, д. 6
<http://www.rudn.ru>
 Утас/факс: +7 (495) 434-70-16,
 +7 (495) 787-38-03*17-84
 И-мэйл: asia@rudn.university



Г.В.ПЛЕХАНОВЫН НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ



Г.В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургууль / ОЭЗИХ / дээд боловсрол эзэмших хүсэлтэй ерөнхий боловсролын сургууль, коллеж төгсөгчдийг урьж байна.

ОЭЗИХ олон жилийн туршид ОХУ-ын олон гарамгай хүмүүсийн ажил албаны хувьд өсөн дэвших гарааны талбай болж байдаг юм. Төрийн олон албан хаагчид, бизнесийн томоохон төлөөлөгчид тус сургуулийн дипломтойгоор ажил амьдралынхаа гарааг эхэлсэн.

Г.В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн гол зорилго нь олон улсын боловсролын стандарт нийцсэн дээд боловсролыг Орос орны дээд боловсролын шилдэг уламжлалаар олгох явдал юм.



Г.В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн Улаанбаатар дахь салбар сүүлийн 16 жилийн туршид эдийн засаг, санхүүгийн салбарын өндөр зэрэглэлтэй мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргаж байна. Тус сургуулийг төгсөгчдийн хэрэгцээ шаардлага нь манай сургуулийн амжилттай үйл ажиллагааны гол үзүүлэлт бөгөөд манай олон төгсөгч ОХУ, Монгол Улсын эдийн засгийн салбарт амжилттай ажиллаж байна.

Улаанбаатарын салбарыг төгсөгчид Г.В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн дипломыг Москва хотод авдаг.

Тус салбар: "Эдийн засаг", "Санхүү, зээл"-ийн мэргэжлээр бакалаврт суралцах элсэлт авч байна. Суралцах хугацаа 4 жил.

Хичээлийг ОХУ-ын дээд боловсролын холбооны боловсролын стандартанд нийцүүлэн орос хэл дээр явуулдаг.

Хөдөө орон нутгаас ирсэн оюутнууд дотуур байраар хангагдах ба 1-р курсийн оюутнууд дотуур байранд үнэ төлбөргүй сууна.

Сургалт төлбөртэй. Сургалтын төлбөрийн хэмжээ 3 480 000 бөгөөд төлбөрийг Монголын орны нутаг дэвсгэр дээр төгрөгөөр авна.

Улаанбаатар дахь салбарын сургалтын өртөг Москва хот дахь төв сургуулиасаа хэд дахин бага.

Г.В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн эрдэмтэн багш нарын оролцоотойгоор хичээл сургуулийг явуулдаг учраас олгодог боловсролын түвшин Москва хот дахь төв их сургуулийн түвшинд нийцдэг.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 210351, Монгол Улс,
Улаанбаатар, Энх тайвны өргөн
чөлөө, 131

И-мэйл: ulan-bator.pk@rea.ru
Утас: +976 99-91-11-68;
8-10-976-11-45-05-96; 8-10-976-
11-45-06-79

Веб-сайт: www.rea.mn
Facebook: <https://www.facebook.com/groups/pleshka/>
Instagram: <https://www.instagram.com/ubpleshka/>



ОРОСЫН УЛС АРДЫН АЖ АХУЙ, ТӨРИЙН АЛБАНЫ АКАДЕМИЙН БАРУУН ХОЙД ДЭЭД СУРГУУЛЬ



Оросын улс ардын аж ахуй, төрийн албаны академийн Баруун хойд дээд сургууль нь ОХУ-ын удирдах албаны дээд сургуулийн бүс нутгийн томоохон дээд сургууль юм. Тус сургууль нь уламжлал инновацийг хослуулан, төрийн алба, удирдлагын салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтыг явуулдаг бөгөөд дорх мэргэжлүүдээр бакалавр, мэргэжилтнүүдийг төгсгөн гаргадаг:

- Төрийн ба орон нутгийн удирдлага
- Олон улсын харилцаа
- Эдийн засаг
- Менежмент
- Хууль
- Гааль
- Бизнес-мэдээлэл зүй
- Эдийн засгийн аюулгүй байдал
- Улс төр судлал

2016 оноос «Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах», «Сэтгүүл зүй», «Сэтгэл судлал», «Нийгмийн ажил» и «Хамт олныг удирдах»

зэрэг мэргэжлүүд бакалаврын олон чиглэлт **Liberal Arts системд** нэгдсэн нь оюутнуудад нэмэлт нарийн мэргэжлийн диплом авах боломжийг олгож байна.

Тус сургуульд боловсролын салбарт бий болсон уламжлал, орчин үеийн трендийн үндсэн дээр боловсрол, шинжлэх ухаан, экспертийн үйл ажиллагааг явуулж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- Боловсролын стандарт нийцсэн эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухааны бүх салбараар хийх;
- Олон улс, бүх оросын болон их дээд сургууль хоорондын эрдэм шинжилгээ- практикийн бага хурлыг зохион байгуулж явуулах;
- Судалгааны бүтээлүүдийг шинжлэх ухааны хэвлэлүүдэд нийтлэх;



- Сонгон шалгаруулах-грантын үйл ажиллагаа

СУРГАЛТАНД НЭВТРҮҮЛСЭН ИННОВАЦ:


- Контентыг тоон системтэй болгох: боловсролын онлайн-курс болон сүлжээгээр суралцагсадтай хамтран ажиллах;
- Компетент хандлага: мэргэжилтэн бэлтгэх бүх чиглэлээр нэр хүндийн карт нэвтрүүлэх;
- Боловсролыг бодгальчлах: сургалтын хувийн даялалыг бий болгох;
- Сургалтын бүхий хугацаанд оюутнуудтай хамтран ажиллах тьюторын институтыг бий болгох;
- Мультимедиа, мобил тавилга, Wi-Fi бүхий орчин үеийн хичээллэх танхимуудыг бий болгох.

Оросын улс ардын аж ахуй, төрийн албаны академийн Баруун хойд дээд сургуульд өнөөдөр – 20000 оюутан суралцаж, 630 багш ажиллан, дээд, дунд боловсролын 45 хөтөлбөр хэрэгжиж байна. 2015 онд тус сургууль ОХУ-ын нийгэм-эдийн засгийн их дээд сургуулиудийн дунд элсэгчдийнхээ чанарын үзүүлэлтээр 13-р байр эзэлж, 2016 онд ОХУ-ын боловсрол, шинжлэх ухааны яамны холбооны шилдэг инновацийн талбарын статусыг хүртсэн.

Манай сургуулийн боломж, давуу талын талаарх илүү тодорхой мэдээллийг талууд бүхэн **4 сарын 16-нд москвгийн цагаар 12.00 цагт болох нээлттэй хаалганы өдөр «СЗИУ Live»** дээр олж авах болоцоотой.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Сүлжээн дэх хаяг
vk.com/sziu_ranepa
Сайт: sziu.ranepa.ru
Тел.: 335-94-94
И-мэйл: info@sziu.ru





Время
учиться
в России

ОРОСОД СУРАЛЦАХ ЦАГ!

«Оросод суралцах цаг!» төсөл нь янз бүрийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг оросын их дээд сургуулийг танилцуулдаг. Энэ талаарх илүү тодорхой мэдээллийг та бүхэн манай их дээд сургуулиудын доорх сайтнаас авч болно:

Үндэсний судалгаа шинжилгээний их сургууль «МЭИ»
<http://mpei.ru/lang/more/mng/Pages/default.aspx>,

Оросын улс түмний найрамдлын их сургууль
<http://www.rudn.ru/>

Москвагийн технологийн институт
<http://mti.edu.ru/>

Москвагийн улсын үндэсний судалгаа шинжилгээний барилгын их сургууль
<http://mgsu.ru/lang/MNG.pdf>

Москвагийн улсын технологийн их сургууль «СТАНКИН»
<http://www.stankin.ru/>

Москвагийн улсын авто замын техникийн их сургууль (МАДИ)
<http://www.madi.ru/>

Үндэсний судалгаа шинжилгээний их сургууль «МИЭТ»
<https://www.miet.ru/>

Новосибирскийн улсын анагаах ухааны их сургууль
<http://www.ngmu.ru/>

Новосибирскийн улсын архитектур-барилгын их сургууль (Сибстрин)
<http://mn.sibstrin.ru/>

«М.И. Платовын нэрэмжит Өмнөд Оросын улсын политехникийн их сургууль» (НПИ)
<http://www.npi-tu.ru/>

ТА БҮХНИЙГ ОРОС
ОРОНД УРЬЖ БАЙНА!

